



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 4/181

Номгон

Орон нутгийн чанартай авто зам, гүүрний барилга,  
засвар, авто зогсоолын барилгын ажилд  
хяналт тавьж, хүлээн авах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 28 дугаар зүйлийн 28.1, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ны 49 дүгээр тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр орон нутагт хийгдсэн авто зам, гүүр, хиймэл байгууламж, авто зогсоолын барилга, засвар арчлалтын ажилд хяналт тавьж хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Мэргэжлийн хяналтын газрын Авто зам, тээврийн хяналтын улсын ахлах байцаагч

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ерөнхий архитектур

Баянхонгор сумын ЗДТГ-ын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Орон нутгийн өмчийн газрын дарга

Замын цагдаагийн тасгийн дарга

“Баянхонгор-тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазрын дарга


Нарийн бичгийн дарга:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн тээврийн бодлого, авто зам хариуцсан мэргэжилтэн

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хэрэгжүүлсэн орон нутагт хийгдсэн зам, гүүр, замын байгууламжийн барилга, засвар арчлалт, авто зогсоолуудын барилгын ажлыг хүлээн авч илэрсэн зөрчлийн арилгуулах, техникийн бичиг

баримтыг бүрдүүлж акт үйлдэж өмчлөлд бүртгүүлэн хүлээн авахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)- т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН